



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/Н22

Арвайхээр


Газар эзэмших эрх шинээр олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 13 дугаар баг Залуучуудын 2-р гудамж Ахмадын өргөөний зүүн талд 0.196 га газрыг Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газарт хүүхдийн цэцэрлэгийн зориулалтаар, 13 дугаар баг Т.Намнансүрэнгийн 6 дугаар гудамж 641 тоотын баруун хойно 0.075 га газрыг аймгийн Засаг даргын Тамгын газарт нийтийн орон сууцны зориулалтаар, Т.Намнансүрэнгийн 7 дугаар гудамж 739 тоотын хойно 0.2838 га газрыг үйлчилгээний зориулалтаар Ж.Самданжигмэд (ЙЮ60121697)-д тус тус 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Дээрх газар эзэмших эрх авсан хуулийн этгээдтэй газар эзэмших гэрээг байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100702